

Монгол, Монгол судлаачдын нүдээр

Докторант Л.Мөнх-Эрдэнэ

1995 оны II сард Принстоны Их Сургуулийн Зүүн хойт Ази сөминаар дээр ХХ зууны Монголын түүхийн асуудлыг олон улсын монгол судлаачид авч үзжээ. Эл сөминарын үр дүн болон бусад судлаачдын өгүүллүүдийг нэгтгэн Принстоны Их сургуулийн зөвлөх Стефан Коткин, Техасын Христосын Их сургуулийн зөвлөх профессор Стефан Коткин, Техасын Христосын Их Сургуулийн туслах профессор Брюс Эллеман нар эрхлэн 1999 оны сүүлээр M.E.Sharpө хэвлэлийн газраас *Mongolia in the Twentieth Century. Land lockèd Cosmopolitan.* /Монгол улс ХХ зуунд. Эх газарт түгжигдсэн космополит/ гэдэг номыг 1999 оны сүүлээр АНУ-д хэвлүүлжээ.

"Эл бүтээл дэлхийн шилдэг, түүний дотор Монголын дөрвөн зохиогч болон судлагаа болон хамгийн сүүлийн үеийн бүтээлүүд дээр тулгуурласан" ажээ. Монгол улсаас МУИС-ийн Түүхийн тэнхмийн эрхлэгч, түүхийн шинжлэх ухааны доктор, профессор Ж.Болдбаатар, Гадаад Харилцааны Яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, түүхийн шинжлэх ухааны доктор Ц.Батбаяр, Гадаад Харилцааны Яамны Гадаад бодлого судлалын төвийн захирал, түүхийн ухааны доктор /Ph/, Г.Төмөрчулуун нар оролцсон байна. Харин А.Хүрэлбаатар нь Өвөр Монголын Их Сургуулийн Монгол хэл, уран зохиолын хүрээлэнгийн профессор аж. Уг ном Стефан Коткины "Монгол улс ба Монголчуудыг хайхуйд: Олон үндэстний Одиссей" гэсэн удиртгал болон "Гадаад Монголын талаарх Хятад-Оросын өрсөлдөөн", "Гадаад Монголын талаарх Олон улсын дипломат бодлого", "Монгол улс өнөөдөр" гэсэн үндсэн турван хэсэг, Г.Төмөрчулууны "Монгол улсын гадаад бодлого" гэсэн төгсгөлөөс бүрджээ.

"Энэ боть дан ганц Монголы улсын төдийгүй, бас Орос, Хятад дахь Монгол нийгэмлэгийг хамран өнгөрсөн зууны Монгол түүхийг шинжлэн үзсэн" үзэл санаа, онол арга зүй, дэвшүүлсэн асуудлын хувьд манай орны эрдэмтэн мэргэд төдийгүй, болдогсон бол Монгол хүн бүр уншиж судалмаар, санаа авмаар бүтээл болжээ. Эл бүтээлийг уншигч олны сонорт хүргэх зорилгыг өвөрлөж, энэхүү бяцхан өгүүллийг тэрлэхэд хүрсэн билээ. Харин хөндсөн, дэвшүүлсэн асуудлуудыг шүүн тунгаах, цаашид гүнзгийрүүлэх, тэлэн судлах нь жич асуудал.

Зохиолд монгол судлалын хөгжлийн замналыг шинжлэхийн хамт, Монгол улс үндэсний улс төрийн тусгаар тогтнол, үндэстний тусгаар тогтнолын төлөөх тэмцэл болон манай орны хөгжлийн хэтийн төлөвийн олон улсын болон гөөполитикийн байр суурь ба түүнээс ургаж, Монголын төрийн явуулж буй гадаад бодлого, хөгжлийн өнөөгийн төлөв байдлынх нь үүднээс монголчуудын үндэсний үзэлтэй уялдуулан авч үзжээ.

Эхний хэсэгт Тайваны эрдэмтэн Мөй-Хуа Лан Хятадын "Шинэ засаг захиргаа Монголд" гэсэн өгүүлэлдээ "манж нар XVII-XVIII зууны турш Монголд улс төр-цэргийн ноёрхолоо тогтоосон бөгөөд ... түүний үндсэн зорилго нь Манжийн эзэнт гүрнийг, ялангуяа түүний умард хэсгийг хамгаалахад монголчуудыг хөдөлгөөнт цэргийн нөөц хүчин болгоход оршиж байв." гээд Манжаас Монголд тогтоосон хошууны систем нь монголчуудын бэлчээрийн төлөөх тэмцлээс хошуудын хооронд гарч болох мөргөлдөөн болон монголчуудыг нэгтгэж чадахуйц улс төрийн удирдагч гарч ирэхээс сэргийлэхэд оршиж байсан юм. Түүнчлэн Манжийн "хуваа, захир" бодлогын дагуу Манж нар Хан хятадуудын нөлөөнөөс монголчуудыг ангид байлгаж байсан гэжээ. Улмаар XIX зууны сүүл үеэр Хятад орон тэнгисийн гүрнүүдийн хагас колони болсон бөгөөд энэ үеэс Манж Монголын харилцаа илүү сул болсон авч Монгол Манжийн хяналтан дор тэдний хаанчлалын бүр төгсгөл- 1912 он хүртэл үлдсэн юм. ХХ зууны эхэн үеэс Манжийн явуулсан "Шинэ засаг захиргааны" бодлогын Монгол руу чиглэсэн гол үзүүр нь Оросын эзэнт улсын санаархалаас өөрийн эзэнт улсын умад хил хязгаарыг хамгаалахын тулд Монголд хятад хүмүүсийг олноор оруулж хятадчлах явдал байв. "Шинэ засаг захиргаа ба Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөн" гэсэн гарчигтаа "олон судлаачид Шинэ засаг захиргааг Гадаад Монголд тусгаар тогтнолын хөдөлгөөнийг бий болгосон гэж

буруутгадаг нь илэрхий хэтрүүлж үнэлсээр байгаагийнх" гээд Монголын тусгаар тогтнолын хөдөлгөөний гол шалгаан нь Манжийн хаанчлалын уналт байсан" гээд үүнийгээ хэд хэдэн талаар нотолсон байна. Тэрээр "тэр ч байтугай Шинэ засаг захиргаа Гадаад Монголд эхлэхээс өмнө Монголчууд Манжийн эзэнт улсаас салах хэрэгтээ Оросоос тусламж авахыг аль эрт оролдож байсан. ... Монголчууд Манжтай тогтоосон өөрсдийн харилцааг альянсийн /холбооны/ нэг төрлөөр ойлгож байсан. Тиймээс Манжийн төр чадваргүй болж, тэдний үйл ажиллагаа ашиггүй болсон үед Монгочлууд Манжтай тогтоосон харилцаагаа эвдэх дургүй байгаагүй нь илэрхий юм гэжээ.

Японы эрдэмтэн Наками Тэтсү "Оросын дипломатууд ба Монголын тусгаар тогтнол" өгүүлэлдээ Монгол Манжийн холбоо бол цэвэр хамжлагын систем: ноёны харилцааг-Чингисийн эзэн хаан, түүний вассалууд нь монголчуудаас бүрдэж байсан юм. Энэ хамжлагын бодлого нь монголчуудад бие даасан нийгмийн тогтолцоогоо хадгалан үлдэх, мөн тэд Манжийн эзэн хаан ба төв засгийн газрын эрх мэдлийг хүндэтгэж байхыг зөвшөөрч байсан юм. ... Хятадын шинэтгэлүүд Монголыг шууд заналхийлсэн ба монголчуудыг Чингийн хаанчлалтай тогтоосон удаан хугацааны харилцаагаа дахин хянаж үзэхэд хүргэсэн. Монголын удирдагчид Монголын нийтмийн уламжлалт тогтолцоог хамгаалах хувилбарыг хайж эхэлсэн ба Халх Монголын улс төрийн удирдагчид Орос руу нууц төлөөлөгчдийг дэмжлэг хүсэхээр илгээхээр шийдсэн" гээд Монголын төлөөлөгчид "хамгаалах"-ыг хүссэнийг нь нэр томъёог буруу ойлгосон Лавдовский уг үгийн хамгийн хүчтэй утгаар ухаж "төлөөлөгчид Оросын засгийн газарт Халхыг түүний протекторат дор авахыг хүссэн албан ёсны санал тавих" мэтээр мэдэгдсэн. "Харин төлөөлөгчдийн ... албан ёсны захидал Оросоос зөвхөн Чингийн шинэтгэлийг зогсооход "туслалцаа", "хамгаалал" үзүүлэхийг цохон хүссэн ба мөн Монгол төлөөлөгчид Оросын засгийн газарт өөрсдийн зорилго нь Монголыг тусгаар тогтоосон үндэстэн болгохоо мэдэгдсэн өөрсдийн меморандумаа тавьсан" гээд энэ гурван баримт бичгээс үзвэл "1911 оны зуны турш Монголын удирдагчдын олонхийн зорилго протекторат ч биш, тусгаар тогтнол ч биш, харин зөвхөн status quo ante-д буцах явдал байсан. Монголын хамгийн радикал шинэтгэгчид болох Ханддорж, Цэрэнчимэд, Хайсан нар Монголын тусгаар тогтнолын төлөө байсан, тиймээс ч тэд үүнийгээ өөрсдийн зохиосон меморандумаа илэрхийлсэн. Оросын Засгийн газар Монголчуудын бие даасан байдлаа хадгалан үлдэх хүсэл эрмэлзлэлийг тэдний ноёнтойгоо, Их Чин эзэн хаантай тогтоосон харилцааг нь таслахгүйгээр дипломат шугамаар дэмжихээр шийдсэн." Гэвч 1911 оны Учаны бослого, улмаар 1911 оны 12-р сарын 1-нд монголчууд тусгаар тогтнолоо тунхаглаж, 12-р сарын 29-нд Засгийн газраа албан ёсоор байгуулсан нь Оросыг Монгол руу баримталж байсан бодлогоо өөрчлөхөд хүргэсэн. Ер нь Оросын засгийн газрын 1911-1915 онд Монгол руу баримталж байсан бодлого нь "хүлээхар" гэсэн байр сууринаас "маш реалист ба болгоомжтой байж", "Эзэнт Орос хамгийн бага чармайлтаар хамгийн их ашиг олохоор найдаж", "Монголын тусгаар тогтнолыг хөөрөгдөхийн оронд Орос зөвхөн үүнд хариу өгсөн" гэж дүгнэжээ. Улмаар Наками Тэтсү "Монголын судлалд БНХАУ ба Тайваны олон эрдэмтэд Гадаад Монголыг тусгаар тогтнолоо тунхаглахыг Орос хүчээр тулгасан гэж зүтгэж байхад Европын болон Америкийн олон эрдэмтэд 1911 оны Монголын тусгаар тогтнолын тунхаглал Эзэнт Оросоор санаачлагдсан ба ивээн тэтгэгдсэн гэж дүгнэх нь нийтлэг бус биш байсаар байна. Өгүүлэн буй архивын мэдээнүүд ямар ч байсан дээрх баримтлалууд нь Монголын бодит байдлыг ихээхэн хэмжээгээр няцааж байгааг үзүүлж байна" гэжээ.

Мөн түүнчлэн номын энэ хэсэгт Э.Эндикот өгүүлэлдээ 1910 онд Монголд ирсэн Москвагийн худалдааны экспедицийн үйл ажиллагаа, улмаар уг экспедици тайландaa Урианхайн хязгаарын талаар "энэ бүс нутаг бага багаар Оросын суурьшгэсдээр колоничлогдоор байгаа ба энэ нь Орос эцсийн эцэст өөрийн эрхийг түүний Урианхай, Л.М./ төлөө шаардахад хүргэх ёстой" гэх зэргээр Оросын эзэнт улсын санаархлыг төлөөлж байсныг, Монтгомери нар Агваан Доржиевыийн зохиосон Буриадын үнэ үсэг буриад-монголын үндэсний үзэл болон улмаар бүх монголчуудыг соёлын хувь, нэгтгэх гэсэн пан-монгол үзлийн эрмэлзлэл байсан хийгээд ЗХУ болон Хятадаас Монголчуудыг

соёлын өвөөс нь таслахын хамт, тэдний хэл, соёлын нийтлэгийг алдагдуулахын тулд явуулсан соёлын бодлогыг авч үзжээ.

Номын хоёрдугаар хэсэгт Е.Бойкова ЗХУ өөрийн геополитикийн эрх ашгийн үүднээс Монголыг нэгэн зэрэг буфер, болзошгүй дайны талбар-холбоотон, "дэлхийн хувьсгалaa" алс дорнодод нэвтрүүлэх түшиц болгох гурван үндсэн зорилгодоо ашиглаж байсан. Тэрээр 1924 оны гэрээгээр "ямар ч байсан Монголын хууль ёсны байдал Олон улсын хуул эрхийн үүднээс Хятадын салшгүй хэсэг хэвээр үлдсэн, энэ нь бусад улс орон БНМАУ-тай албан ёсны дипломат харилцаа тогтоохыг хүсэхгүй хэвээр үлдэнэ гэсэн хэрэг. Үр дүнд нь Гадаад Монголын дипломат тусгаарлагдмал Зөвлөлт Холбоот улсад Монголд өөрийн улс төр, эдийн засгийн байр сууриа бэхжүүлэхэд саадгүй боломжийг олгосон юм" гээд 1939 он хүртлэх Зөвлөлт-Монголын харилцаанд зөвхөн аргагүй байдалд байгаа Монголын удирдагчид тухайлбал, Г.Дэмид "Зөвлөлт Холбоот улс Монголыг Зөвлөлтийн колони болгох" гэлээ гэх зэрэгээр Зөвлөлтийн эзэрхэг бодлогыг эсэргүүцэж байсан. Тэрээр "илүү их эрх чөлөө олж авах гэсэн Монголчуудын аливаа чармайлтыг Зөвлөлтийн нууц албад залхаан цээрлүүлж" байсаныг П.Гэндэн, Г.Дэмид нарын жишээгээр өгүүлжээ.

Б.Эллеман 1890-ээд оноос Хаант Орос улмаар 1940 оны сүүл үе хүртэл ЗХУ Алс Дорнод ялангуяа Монголд сонирхолын хүрээгээ хэрхэн бэхжүүлснийг Зөвлөлт-Япон, Зөвлөлт-Хятадын харилцааны үүднээс авч үзсэн бол К.Атвууд "Зөвлөлт-Хятадын дипломат бодлого ба Монголын хоёрдахь хуваагдал 1945-1946" өгүүлэлдээ Монгол улсын тусгаар тогтолцоо албан ёсоор хүлээн зөвшөөрүүлсний үнэ цэн, Сталины хоёр нүүртэй бодлого, маршал Чойбалсаны Монголыг нэгтгэж "Ихээхэн Монгол" улс байгуулах эрмэлзлэлийг "адилхан орон дээр унтаж, онд ондоо зүүд зүүдэлж" байсан гэж Хятадын зүйр үгээр илэрхийлжээ.

Номын энэ хэсэгт дайны дараах үеэс албан ёсны бус байдлаар эхэлсэн Монгол-Японы харилцаа хэрхэн хэвийн болж улмаар 1990-ээд оноос Монгол улс Зөвлөлтийн хяналтгүйгээр өөрийн үндэсний эрх ашгийн үүднээс явуулж буй "гурав дахь хөршийг" бий болгох гадаад бодлогын үр дүнд жирийн Монгол хүний хувьд "дайсан", "дайнч самурайн" дүрээр ойлгогдож байсан "Япон нь АНУ, Герман болон бусдын хамт энэ бодлогын нэн чухал орон болсныг" доктор Ц.Батбаяр өгүүлэлдээ онцлон тэмдэглэж, хоёр орны ард түмний харилцан ойлголцол, хамтын ажиллагаа хэрхэн гүнзгийрч буйг түүх, архивын баримтуудаар үнэмшилтэй нотолсон байна.

Номын гуравдугаар хэсгийн эхэнд Өнөөгийн Хятад дахь Монголчуудын тоймыг Өвөр Монголын эрдэмтэн А.Хүрэлбаатар өгүүлэлдээ авч үзэж Хятадад 4.8 сая монголчууд тоологдож байгаа бөгөөд, XX зууны турш соёлын уусалтын үйл явц явагдаж буй гаргахын хамт 1970-аад оны сүүл үеэс эхлэн Хятадын Монголчуудын дунд уламжлалт соёлоо дахин эзэмших эмзэг үйл явц үргэлжилж байгаа хийгээд энэ нь Хятадын хэсэг болон байхдаа бие даасан соёлын болон угсаатны адилсалaa хадгалан үлдэх найдвар нь болохыг харуулжээ.

Ийнхүү Хятад дахь Монголчууд соёлоо хадгалан үлдэхийг хичээж байхад БНМАУ-ын үед Зөвлөлтийн "асрамжинд", улсын социализмын эрин үөийг туулсан Монголчууд ч өөрийн өв уламжлалаа сэргээхээр зүтгэж байгаа боловч, явагдаж буй зах зээлийн эдийн засгийн шинэтгэл нь Монголын уламжлалт бэлчээрийн тогтолцоог хэрхэн эвдэж буйг Д.Сниф Монголын уламжлалт бэлчээрийн тогтолцоог ав чүзсэн өгүүлэлдээ тусгажээ.

Маш тодорхой зүйл бол чухам энэ номын мэндэлсний, энэ утгаараа олон улсын Монгол судлалын өдий зэрэгтэй хөгжсөний, илүү гүн авч үзвэл Монгол улс, монголчуудыг хоёрдахь мянган жилтэй золгуулсны гол "буруутан" нь бидний монголчуудын үндэсний үзэл юм. Доктор Ж.Болдбаатарын өгүүлэл чухам энэ "буруутан"-д анхаарал хандуулжээ. Өгүүлэн буй зууны турш Монголын үнэдэсний үзэл өөрийн эрх чөлөөг хайсаар, боломж олдох бүрт илрэн гарч байсны нэг жишээ нь Сталины дараа 1962 онд улс төрийн хувьд ч, соёлын хувьд ч хөндүүр асуудал болох Чингис хааны мэндэлсний найман зуун жилийн ойг тэмдэглэсэн явдал юм. Учир нь

"Чингис хаан феодал удирдагч байсан учир марксист-ленинист орчин үеийн хөгжилтийн үзэлд ад зэтгэр нь байсан. Түүгээр ч барахгүй түүний байгуулсан нэгдсэн Монгол улс тухайн БНМАУ-ын социалист халамжлагч ЗХУ-ын болон одоогийн нутаг дэвсгэрийг өмнөд хөрш БНХАУ-ыг байлдан дагуулж захирч байсан билээ. Хэдий тийм боловч 1949 онд "Чингис бол одоогийн Гитлөр шиг" гэж хэлж байсан Монголын хамгийн коммунист удирдагч Ю.Цэдэнбал ч энэ ойг тэмдэглэхийг дэмжиж, улмаар МАХН-ын ТХ-ы тогтоол гарч Чингис хааны хөшөөг Улаанбаатарт босгохоор төлөвлөх зэргээр хөлтэй бэлтгэж эхэлсэн боловч, Орос ахынхаа бяцхан анхааруулгаас эмээж, Хэнтий аймагт босгох зэргээр даруухан өнгөрөөсөн, төдийгүй ажлын хэсгийнхэн зэмлэл хүртсэн боловч энэ үйл явдал нь Монголын үндэсний үзэл санаа гучиад жилийн дараа дахин сэргэснийг Ж.Болдбаатар өөрийн өгүүлэлдээ гарган тавьжээ. Мөн Т.Гинзбург монголчуудын үндэсний үзлийг өнөөгийн монголын нийгмийн шилжилт болон элитүүдтэй холбон, 1940-1950-иад онуудад төрсөн ЗХУ болон Зүүн Европын орнуудад голчлон техникийн салбарын боловсрол эзэмшсэн 50 гаруй засаглагч элитийг оруулан сэхээтэн болон технократуудаас бүрдсэн "магадгүй бүхэлдээ 300-аар тоологох оюуны ба засаг захиргааны лидерүүд" өнөөгийн ачааны хүндийг хэрхэн үүрч, түүчээлэн явааг авч үзжээ. Зохиогч монголын өнөөгийн үндэсний үзэл нь ХХ зууны эхэн үеийнхтэй ижил бөгөөд энэ нь үндэсний тусгаар тогтол, нийгмийн модернизаци гэсэн хоёр асуудал төвлөрч, Монголын геополитикийн байршил, олон улсын хүрээлэн байгаа орчиноос ургаж байгаа бөгөөд Монгол улс гадаад, дотооддоо мөн л үүнтэй эвлэрсэн pragmatik бодлого явуулахаас өөр аргагүй байгаа. Тиймээс Монголын үндэсний үзэл нь үндэсний болон олон улсын үзэл суртлыг хослуулсан pragmatik космополитан бөгөөд илэрхий улс төрийн гэхээсээ илүү соёлын шинж чанартай гэжээ. Гинзбургийнхээр Латтиморын дүрсэлснээр Оростой харилцаагаа хадгалах хамгийн чадвартай монголчуудад эрх мэдэл ирдэг гэсэн шиг өнөөгийн монголчууд "эхлээд умар зүг харж байгаа" бөгөөд орчин үеийн Монголын "гадаад харилцааны байнгын хамгийн чухал орон нь Орос, энэ факттай хэрхэн харьцах вэ гэдэг бол үргэлжийн асуудал". Энэ нь Монголын үндэсний үзлийн төвд байгдаг ажээ.

Г.Төмөрчуулун "... хэрвээ Орос эрчимтэй супарвал Хятад, Монгол дахь геополитикийн сонирхлоо өргөтгөх төгс боломж бий боллоо гэж шийдэж болох ..." гэсэн нь ч дээр өгүүлснийг нотлох мэт. Гэхдээ түүнийхээр Монгол хэзээ ч тоталитар дэглэмд эргэж орохгүй /Orwellian Day/ бөгөөд өнөөдрийн Монгол Оросын эсвэл хятадын бэлдмэл /magis nostrum/ байхаа больж, "дэлхийн зүрхийг байлдан дагуулсан" учир "Монголыг оруулаагүй дэлхийн зураг хялавхийхийн ч үнэгүй" болсон ажээ.

Гэхдээ л Стефен Коткиныхоор Монголчуд космополитан үзэлтэй, 2,3-хан сая хүн амтай, түүнийх нь 75% нь 35 наснаас доошли, 50, илүү нь 21 нас хүртлэх залуучуудаас бүрдсэн үндэснийхээ адилсалыг хайж буй ард түмэн бөгөөд геополитикийн байрлалаасаа шалтгаалан "нээлттэй хаалганы" бодлого явуулж байгаагийнхаа хамт глобальчлалын эрин үед тулгараад байгаа бөгөөд Монгол ба монголчуудыг эрэх нь "олон үндэстний одиссейн" хэрэг болсон ажээ. Дэлхийн түүхийг төрүүлсэн, Америкийн индианчуудын хувь заяаг давтхаас хамгийн их айдаг энэ ард түмнийг ийм хувь заяа хүлээж байгаа юм болов уу, хэрвээ тийм бол чухам ямар соёл, ямар үндэстэн, зонхилсон одиссей энэ утгаараа космополитан үгийн хоёрдахь утгаар Монгол хэний орон зайд болох? Энэ бүхэнд Коткины факт болгон аваад байгаа залуучууд давамгайлсан бидний ард түмэн гол хариултыг өгөх эрхтэй, бас тийм хариуцлагатай болов уу. Уг хариулт нь эл номын гол "буруутан" болсон бидний монголчуудын үндэсний үзлээс голчлон шалтгаалах бөгөөд тэр нь бидний хүсэл зориг, итгэл үнэмшлээс бүрддэг билээ.